



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хотонт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Грут финанс Аудит ХХК-ийн

Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж

Утас: 77721628

Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 60
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХОТОНТ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ А.БАЯНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,150,392.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,102,279.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 үндсэн зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	165,644,160.58	84,588,449.19
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	154,703,060.58	58,631,357.89
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	154,703,060.58	58,631,357.89
3121	Төгрөг	154,703,060.58	58,631,357.89
31211	Төрийн сангийн харилцах	154,703,060.58	58,631,357.89
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	10,941,100.00	25,957,091.30
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	10,941,100.00	25,957,091.30
35410	Бичиг хэргийн материал	300,500.00	225,500.00
35420	Аж ахуйн материал	10,571,600.00	10,438,900.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,345,000.00
35460	Хүнсний материал	-	1,472,761.30
35470	Бусад хангамжийн материал	69,000.00	10,474,930.00
346	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	392,153,311.55	2,939,002,878.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	392,153,311.55	2,939,002,878.34
392	Биет хөрөнгө	378,093,311.55	2,928,002,878.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	352,598,498.59	2,875,345,228.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,409,747.15)	(35,941,815.36)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	43,153,473.00	48,605,973.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,901,413.17)	(16,909,107.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,890,916.73	65,279,441.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,958,446.45)	(8,486,840.54)
39217	Ном	720,030.00	110,000.00
393	Биет бус хөрөнгө	14,060,000.00	11,000,000.00
39301	Програм хангамж	-	1,200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,060,000.00	9,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	557,797,472.13	3,023,591,327.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	557,797,472.13	3,023,591,327.53
51	Засгийн газрын хувь оролцоо	557,797,472.13	3,023,591,327.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	95,141,920.00	95,141,920.00
51101	Өмч: - төрийн	95,141,920.00	95,141,920.00
512	Хуримтлагдсан үр дүн	412,392,573.06	2,927,169,342.53
51210	Өмнөх үеийн үр дүн	412,392,573.06	461,375,487.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,465,793,855.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,262,979.07	1,280,065.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	557,797,472.13	3,023,591,327.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	936,246,568.13	3,946,174,408.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,467,168.13	2,938,778,208.05
120	Нийтлэг татварын бус орлого	34,467,168.13	2,938,778,208.05
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө	34,467,168.13	2,914,949,628.05
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	-	23,828,580.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	901,779,400.00	1,007,396,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	868,895,700.00	952,366,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	868,895,700.00	952,366,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,883,700.00	55,030,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,883,700.00	55,030,100.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	832,221,274.61	1,157,688,320.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	832,221,274.61	1,157,688,320.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	827,532,374.61	1,156,499,820.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607,832,417.11	841,252,974.89
210101	Цалин	393,509,921.32	537,252,064.70
210102	Нэмэгдэл цалин	185,225,594.01	255,288,405.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	200,000.00	7,997,668.00
210104	Урамшуулал	28,896,901.78	40,714,836.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,387,107.93	100,127,800.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	51,649,178.69	68,081,900.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	6,060,117.55	8,003,800.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,086,500.67	4,008,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,702,709.00	4,008,100.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	10,888,602.02	16,025,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,916,100.00	46,535,100.00
210301	Гэрэл цахилгааны зардал	9,178,433.23	9,952,748.09
210302	Түлш, халаалтын зардал	18,008,746.77	28,410,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	728,920.00	8,172,351.91
2104	Хангамж, бараа материалын зардал	-	720,030.00
210404	Ном, хэвлэл	-	720,030.00
2105	Нормативт зардал	69,046,435.00	76,398,886.50
210502	Хоол, хүнс	69,046,435.00	76,398,886.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,967,600.00	3,961,500.00
210604	Урсгал засвар	4,967,600.00	3,961,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,785,800.00	4,146,300.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,785,800.00	4,146,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,596,914.57	83,357,229.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,633,600.00	17,374,470.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	6,291,300.00	7,831,310.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,672,014.57	58,151,449.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,688,900.00	1,188,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,188,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,188,500.00

Архангай аймгийн Хотонт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,688,900.00	-
213305	Хөрөнгийн	4,688,900.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	104,025,293.52	2,788,486,087.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЫН ДҮН 4	-	322,692,231.97
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	309,338,581.97
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	13,353,650.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	104,025,293.52	2,465,793,855.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	901,779,400.00	1,007,396,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	901,779,400.00	1,007,396,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	868,895,700.00	952,366,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	868,895,700.00	952,366,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,883,700.00	55,030,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,883,700.00	55,030,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	814,993,300.04	1,103,357,902.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	814,993,300.04	1,103,357,902.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	814,993,300.04	1,102,169,402.69
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	607,520,969.26	841,251,520.89
210101	Үндсэн цалин	394,397,628.38	537,250,610.70
210102	Нэмэгдэл	184,625,606.30	255,288,405.92
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	200,000.00	7,997,668.00
210104	Урамшуулал	28,297,734.58	40,714,836.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,698,555.78	100,127,800.00
210201	Тэтгэврийн даатгал	50,185,372.70	68,081,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,336,512.52	8,003,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,175,447.52	4,008,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,329,100.00	4,008,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,672,123.04	16,025,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,883,700.00	49,880,100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,178,433.23	9,952,748.09
210302	Түлш, халаалт	17,976,346.77	31,755,000.00
210303	Цэвэр, бохир ус	728,920.00	8,172,351.91
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	69,034,875.00	77,557,111.80
210502	Хоол, хүнс	69,034,875.00	77,557,111.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	3,961,500.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	3,961,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,592,400.00	4,146,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,592,400.00	4,146,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,262,800.00	25,245,070.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,984,100.00	18,150,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,278,700.00	7,094,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,188,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,188,500.00

Архангай аймгийн Хотонт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв	-	1,188,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	86,786,099.96	(95,961,702.69)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,499,900.00	110,000.00
	Дотоод эх үүсвэрээр	2,499,900.00	110,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,499,900.00	110,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,499,900.00)	(110,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	84,286,199.96	(96,071,702.69)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	70,416,860.62	154,703,060.58
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	154,703,060.58	58,631,357.89

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	95,141,920.00	50,262,979.07	308,367,279.54	453,772,178.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,141,920.00	50,262,979.07	308,367,279.54	453,772,178.61
Тайлант үеийн үр дүн	-	-	104,025,293.52	104,025,293.52
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	95,141,920.00	50,262,979.07	412,392,573.06	557,797,472.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,141,920.00	50,262,979.07	412,392,573.06	557,797,472.13
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(48,982,914.07)	48,982,914.07	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,465,793,855.40	2,465,793,855.40
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	95,141,920.00	1,280,065.00	2,927,169,342.53	3,023,591,327.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансн код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,152,736,600.00	1,102,279,402.69	50,457,197.31	95.62
УРСГАЛ ЗАРДАЛ		1,152,736,600.00	1,102,279,402.69	50,457,197.31	95.62
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,152,736,600.00	1,102,279,402.69	50,457,197.31	95.62
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		870,328,300.00	841,251,520.89	29,076,779.11	96.66
Үндсэн цалин	210101	582,272,100.00	537,250,610.70	45,021,489.30	92.27
Нэмэгдэл	210102	258,653,300.00	255,288,405.92	3,364,894.08	98.70
Унаа хоолны Хөнгөлөлт	210103	-	7,997,668.00	(7,997,668.00)	-
Урамшуулал	210104	29,402,900.00	40,714,836.27	(11,311,936.27)	138.47
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		107,918,800.00	100,127,800.00	7,791,000.00	92.78
Тэтгэврийн даатгал	210201	73,199,500.00	68,081,900.00	5,117,600.00	93.01
Тэтгэмжийн даатгал	210202	8,679,800.00	8,003,800.00	676,000.00	92.21
ҮОМШӨ-ний даатгал	210203	4,339,900.00	4,008,100.00	331,800.00	92.35
Ажилгүйдлийн даатгал	210204	4,339,900.00	4,008,100.00	331,800.00	92.35
Эрүүл мэндийн даатгал	210205	17,359,700.00	16,025,900.00	1,333,800.00	92.32
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		49,880,100.00	49,880,100.00	-	100.00
Гэрэл, цахилгаан	210301	16,744,300.00	9,952,748.09	6,791,551.91	59.44
Түлш, халаалт	210302	31,755,800.00	31,755,000.00	800.00	100.00
Цэвэр, бохир ус	210303	1,380,000.00	8,172,351.91	(6,792,351.91)	592.20
Хангамж, бараа материалын зардал		-	-	-	-
Нормативт зардал		86,170,100.00	77,557,111.80	8,612,988.20	90.00
Хоол, хүнс	210502	86,170,100.00	77,557,111.80	8,612,988.20	90.00
Эд хогшил, урсгал засварын зардал		5,150,000.00	3,961,500.00	1,188,500.00	76.92
Урсгал засвар	210604	5,150,000.00	3,961,500.00	1,188,500.00	76.92
Томилот, зочны зардал		-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,146,300.00	4,146,300.00	-	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210806	4,146,300.00	4,146,300.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал		29,143,000.00	25,355,070.00	3,787,930.00	87.00
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	22,048,700.00	18,260,770.00	3,787,930.00	82.82
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	210902	7,094,300.00	7,094,300.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		-	-	-	-
Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг		-	-	-	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	-	-	-
Дотоод эх үүсвэрээр		-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,152,736,600.00	1,006,207,700.00	146,528,900.00	87.29
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		1,097,706,500.00	952,366,100.00	145,340,400.00	86.76
Улсын төсвөөс санхүүжих	131001	956,625,300.00	952,366,100.00	4,259,200.00	99.55
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	131009	141,081,200.00	96,071,702.69	45,009,497.31	68.10
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		55,030,100.00	53,841,600.00	1,188,500.00	97.84
Орон нутгийн төсвөөс	132001	55,030,100.00	53,841,600.00	1,188,500.00	97.84
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		154,703,060.58	154,703,060.58	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		154,703,060.58	58,631,357.89	96,071,702.69	37.90

ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
БАЙГУУЛЛАГЫН ТОО		1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО		30.00	30.00	-	100.00
Удирдах ажилтан		1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан		16.00	16.00	-	100.00
Үйлчлэх ажилтан		13.00	13.00	-	100.00
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		180.00	180.00	-	100.00
Төрийн өмчит СӨБ байгууллага		180.00	180.00	-	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		30.00	30.00	-	100.00
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		17.00	17.00	-	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		12.00	12.00	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 23,583.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

- 2025.12.31-нээр үндсэн хөрөнгийн тайлангийн үлдэгдэл, орлого, зарлагыг харгалзах ерөнхий дэвтрийн дүнгийн үлдэгдэл, дебет, кредиттэй тулгахад 23,583.0 мянган төгрөгийн зөрүү гарсан. Үүнээс 23,773.0 мянган төгрөг нь тайлант хугацааны элэгдлийг дутуу байгуулсантай холбоотой бол 199.0 мянган төгрөг нь өмнөх тайлант хугацаанд үүссэн зөрүү байв.

Аудитаар залруулаагүй 3,806.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 1,142.6 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 2,664.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3,806.6 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 12,895.7 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Нэр бүхий 7 ажилтанд эрхлэгчийн тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл 902.6 мянган төгрөгийг олгосон..

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 "харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх", "ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2 "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Dynamic SR 1.0 төсвийн гүйцэтгэлийн программын 2025 оны жилийн төлбөр 160.0 мянган төгрөгийг давхардуулан шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" мөн зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.3. 2-оос 4 дүгээр сарын хоолны мөнгийг олгохдоо нэр бүхий 7 ажилтны хоногийн гүйцэтгэлийг буруу тооцон 80.0 мянган төгрөг илүү олгожээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. "Балансын урамшуулал олгох тухай" Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаалаар "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Элэгдэл дутуу байгуулсан	1	23,583.0	1.0	23,583.0			1
Нийт дүн	1	23,583.0	1.0	23,583.0	-	-	1	23,583.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү тооцож олгосон	1	902.6	1	902.6				

Архангай аймгийн Хотонт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоолны хөнгөлөлт илүү тооцож олгосон	1	80.0	1	80.0				
Илүү төлөлт хийсэн	1	160.0	1	160.0				
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0			1	2,664.0		
Дүн	4	3,806.6	3	1,142.6	1	2,664.0	-	-